



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2003 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 234

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2003-2004 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2003 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Цэдэн овогтой Одгэрэлийг АНУ-ын Де Врай Их сургуулийн Келлер Удирдлагын сургуулийн магистрантурт хөдөө аж ахуйн бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Бямбаа овогтой Төмөрбатыг Англи улсын Бирмингхамын Их сургуулийн магистрантурт эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээний бодлого, удирдлагын чиглэлээр 1 жилийн хугацаагаар, Бадамжунай овогтой Оюунбилэгийг Канад улсын Ватерлоогийн Их сургуулийн магистрантурт аялал жуулчлалын бодлого, төлөвлөлтийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Шадав овогтой Оюунцэцэггийг АНУ-ын Денвер хот дахь Колорадогийн Их сургуулийн докторантурт иргэний барилгын инженерийн чиглэлээр 3 жилийн хугацаагаар 2003-2004 оны хичээлийн жилээс тус тус суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

А.ЦАНЖИД

03235